

**МОНГОЛ УЛСЫН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН
САНГИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН
2026 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2026
ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ГУРАВ ДАХЬ
ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 11 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг

Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 9 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаараа явуулж, Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг бэлтгэн Улсын Их Хурлын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулсан.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулах үед Төсвийн байнгын хорооноос бэлтгэсэн Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй зарим саналуудтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.14 дэх хэсэгт заасны дагуу төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзэн Төсвийн байнгын хороонд буцаасан.

Төсвийн байнгын хороо 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг дахин явуулж, ажлын хэсэг болон чуулганы нэгдсэн хуралдаанаас чиглэл өгч буцаасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, санал хураалт явуулан олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол, санал, дүгнэлтийн хамт Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн гурав дахь хэлэлцүүлгийг дахин явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Х.ГАНХУЯГ